



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/553

Алтай хот

Шилдэг багшийг урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, 41.2.7 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.2.1, 3.1.6 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 39 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багшийн ажлын гүйцэтгэлд нь суурилан хөгжүүлж, урамшуулж, хариуцлагыг нэмэгдүүлэн боловсролын салбарын шилдэг багшийг урамшуулах зардлыг хавсралтаар баталсугай.


2.Урамшуулалд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаж ажиллахыг Боловсролын газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.


4.Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2021 оны  
 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/553 дугаар  
 захирамжийн хоёрдугаар хавсралт



Боловсролын салбарын шилдэг багшийг урамшуулах төсвийн зардал

д/д	Зарцуулалт	Ангилал	Хүний тоо	Нэг хүнд ногдох мөнгөн дүн	Нийт
1	Үндэсний шилдэг багш	Эхний 10-т орсон	2	2500000	5000000
		эхний 50-т орсон	1	400000	400000
2	Сайн хичээл-Цахим уралдаан	1-р байр	22	259000	5700000
		2-р байр	21	200000	4200000
		3-р байр	23	100000	2300000
3	ТХБ	Дэлхийн том хичээл	8	300000	2400000
				Нийт	20,000,000